ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/07/НА-СТА-ТТЗ**

---


Хөвсгөл аймаг Төрийн Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № 01/273

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ
СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧ З.НЯМ-ОЧИР ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2/5-д заасны дагуу Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 76.6 сая төгрөг болж, өмнөх оноос 35.9 сая төгрөгөөр буурсан байна.

**Аудитын гол асуудал**

Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 11 нэр төрлийн 70.4 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын 167 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 92.5 хувьтай биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6724040691

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | 669,377.0 | 583,554.2 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3а, 3б | 462,909.6 | 379,885.2 |
| **33** | **АВЛАГА** | 5а, 5б, 6а, 6б | 112,619.7 | 76,668.5 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8а, 8б, 8в | 93,847.6 | 127,000.5 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | 1,798,558.6 | 1,903,576.9 |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 11а, 11б | 60,500.0 | 202,175.0 |
| **37300** | **Урт хугацаат зээл** | | 60,500.0 | 202,175.0 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12а, 12б, 12в | 1,738,058.6 | 1,701,401.9 |
| **39200** | **Биет хөрөнгө** | | 1,340,364.6 | 1,304,049.9 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 13 | 397,694.0 | 397,352.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | 2,467,935.6 | 2,487,131.1 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 68,160.5 | 2,812.0 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15а, 15б | 68,160.5 | 2,812.0 |
| **41300** | **Өглөг** | 17а, 17б | 68,160.5 | 2,812.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | 2,399,775.1 | 2,484,319.1 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 2,399,775.1 | 2,484,319.1 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 1,456,950.2 | 1,456,950.2 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 1,500.0 | 1,500.0 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | | 623,377.7 | 707,921.7 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 317,947.1 | 317,947.1 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | 2,467,935.6 | 2,487,131.1 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | 1,157,971.9 | 1,330,691.3 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | 391,719.0 | 527,437.0 |
| **110** | **Орлогын албан татвар** | | 186,805.1 | 232,845.6 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | | 198,367.4 | 243,258.2 |
| **1101** | **Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт** | | -11,562.3 | -10,412.6 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | | 47,318.0 | 81,815.7 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | | 157,595.9 | 212,775.7 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 1а, 1б | 52,745.0 | 38,143.8 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 52,745.0 | 38,143.8 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | 713,507.8 | 765,110.6 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 2а, 2б | 1,103,838.1 | 1,244,147.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 1,103,838.1 | 1,244,147.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 1,013,531.4 | 1,043,057.7 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 414,178.8 | 486,689.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 50,431.2 | 52,802.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 146,466.4 | 25,259.3 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 62,693.6 | 101,080.4 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 34,970.0 | 9,692.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 1,400.0 | 2,880.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 75,534.6 | 118,777.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 227,856.8 | 245,875.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 90,306.7 | 201,089.7 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | 54,133.8 | 86,544.0 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 3,012,806.8 | 2,000.0 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | -2,958,673.0 | 84,544.0 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | | 1,218,628.6 | 1,362,734.3 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 391,719.0 | 527,437.0 |
| 110 | Орлогын албан татвар | | 186,805.1 | 232,845.6 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 198,367.4 | 243,258.2 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -11,562.3 | -10,412.6 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 47,318.0 | 81,815.7 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 157,595.9 | 212,775.7 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 18,752.5 | 13,482.9 |
| 1181 | Газрын төлбөр | | 45,079.8 | 120,034.0 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | | 93,763.6 | 79,258.7 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 113,401.8 | 70,186.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 113,401.8 | 70,186.8 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 713,507.8 | 765,110.6 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 1,089,316.5 | 1,221,432.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,089,316.5 | 1,221,432.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 747,130.0 | 956,726.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 412,505.2 | 479,688.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 51,374.8 | 59,954.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 147,370.6 | 34,059.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 29,298.8 | 38,480.7 |
| 2105 | Нормативт зардал | | 0.0 | 900.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 44,443.4 | 11,853.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 1,400.0 | 2,880.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 53,281.7 | 314,951.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 7,455.4 | 13,958.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 342,186.4 | 264,706.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | | 129,312.2 | 141,301.4 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | | 34,942.5 | 15,325.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 34,942.5 | 15,325.9 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 34,942.5 | 15,325.9 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | | -34,942.5 | -15,325.9 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | | 0.0 | -209,000.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | | 0.0 | 209,000.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | | 94,369.6 | -83,024.5 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 368,540.0 | 462,909.6 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 462,909.6 | 379,885.2 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,082,745.0 | 0.0 | 5,082,745.0 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -71,776.9 | 0.0 | -71,776.9 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,010,968.1 | 0.0 | 5,010,968.1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | 347,480.0 | 0.0 | 347,480.0 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | -2,958,673.0 | 0.0 | -2,958,673.0 |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,399,775.1 | 0.0 | 2,399,775.1 |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,399,775.1 | 0.0 | 2,399,775.1 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 2,399,775.1 | 0.0 | 2,399,775.1 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 84,544.0 | 0.0 | 84,544.0 |
| **20** | **2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | 2,484,319.1 | 0.0 | 2,484,319.1 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,631,434.40** | **1,350,000.37** | **281,434.03** | 82.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,341,384.40** | **1,127,571.47** | **213,812.93** | 84.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **959,041.80** | **877,448.87** | **81,592.93** | 91.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **519,670.20** | **479,688.75** | **39,981.45** | 92.3 |
| 210101 | Үндсэн цалин | 408,609.30 | 321,110.97 | **87,498.33** | 78.6 |
| 210102 | Нэмэгдэл | 107,060.90 | 144,473.63 | **-37,412.73** | 134.9 |
| 210104 | Урамшуулал | 4,000.00 | 14,104.15 | **-10,104.15** | 352.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **72,659.30** | **59,954.64** | **12,704.66** | 82.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,212.20 | 37,119.41 | **8,092.79** | 82.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,056.10 | 6,424.10 | **2,632.00** | 70.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,044.90 | 4,317.30 | **1,727.60** | 71.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,011.30 | 1,561.17 | **-549.87** | 154.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,334.80 | 10,532.64 | **802.16** | 92.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **190,521.30** | **181,621.75** | **8,899.55** | 95.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 32,361.30 | 28,554.09 | **3,807.21** | 88.2 |
| 210302 | Түлш, халаалт | 148,500.00 | 151,153.25 | **-2,653.25** | 101.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,660.00 | 1,914.41 | **7,745.59** | 19.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **39,690.00** | **37,669.14** | **2,020.86** | 94.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,200.00 | 6,200.00 | **0.00** | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,050.00 | 19,372.44 | **1,677.56** | 92.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,540.00 | 3,190.00 | **350.00** | 90.1 |
| 210404 | Ном, хэвлэл | 450.00 | 460.00 | **-10.00** | 102.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,450.00 | 8,446.70 | **3.30** | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **900.00** | **900.00** | **0.00** | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 900.00 | 900.00 | **0.00** | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **42,856.20** | **42,853.20** | **3.00** | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500.00 | 2,500.00 | **0.00** | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 40,356.20 | 40,353.20 | **3.00** | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,900.00** | **2,880.00** | **20.00** | 99.3 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,900.00 | 2,880.00 | **20.00** | 99.3 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **75,824.00** | **57,923.41** | **17,900.59** | 76.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 74,424.00 | 56,781.06 | **17,642.94** | 76.3 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 400.00 | 235.00 | **165.00** | 58.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400.00 | 307.35 | **92.65** | 76.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600.00 | 600.00 | **0.00** | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,020.80** | **13,957.99** | **62.81** | 99.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,300.00 | 7,300.00 | **0.00** | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,720.80 | 6,657.99 | **62.81** | 99.1 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **382,342.60** | **250,122.60** | **132,220.00** | 65.4 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **378,592.40** | **247,132.60** | **131,459.80** | 65.3 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 378,592.40 | 247,132.60 | **131,459.80** | 65.3 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,750.20** | **2,990.00** | **760.20** | 79.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,750.20 | 2,990.00 | **760.20** | 79.7 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **18,000.00** | **13,428.90** | **4,571.10** | 74.6 |
| 223001 | Бусад хөрөнгө | 18,000.00 | 13,428.90 | **4,571.10** | 74.6 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **272,050.00** | **209,000.00** | **63,050.00** | 76.8 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 272,050.00 | 209,000.00 | **63,050.00** | 76.8 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,631,434.40** | **1,314,730.66** | **316,703.74** | 80.6 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **194,092.40** | **186,092.40** | **8,000.00** | 95.9 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 194,092.40 | 186,092.40 | **8,000.00** | 95.9 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,022,185.80** | **1,077,342.00** | **-55,156.20** | 105.4 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,022,185.80 | 1,077,342.00 | **-55,156.20** | 105.4 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **415,156.20** | **51,296.26** | **363,859.94** | 12.4 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,000.00 | 42,050.99 | **17,949.01** | 70.1 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,500.00 | 9,245.27 | **-3,745.27** | 168.1 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 349,656.20 | 0.00 | **349,656.20** | 0.0 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **17.00** | **17.00** | **0.00** | 100.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **0.00** | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | **0.00** | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **8.00** | **8.00** | **0.00** | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 6.00 | 6.00 | **0.00** | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 2.00 | 2.00 | **0.00** | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **8.00** | **8.00** | **0.00** | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 2.00 | 2.00 | **0.00** | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6.00 | 6.00 | **0.00** | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **81,038,976.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **81,038,976.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **81,038,976.00** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **-26,226,544.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | -3,966,544.58 |
| 210302 | Түлш, халаалт | -22,260,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **811,595.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 811,595.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-3,500,000.00** |
| 210604 | Урсгал засвар | -3,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **109,953,925.58** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 109,953,925.58 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **81,038,976.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **81,038,976.00** |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 59,492,729.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,933,595.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 612,652.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа 2 байгууллага, орон нутгийн 2 тусгай сан, Мөнх хаан савдаг ХХК-ийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан ЗДТГ-ын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 138.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 138.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг хүргүүлж байна. Дээрх зөрчлийг материаллаг зөрчилд тооцоогүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 10 нэр төрлийн 68.4 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.”хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр ханган биелүүлж ажиллах.

**2. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой:**

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 69.6 сая төгрөг байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоо хөгжүүлэх сангийн журам”-ын 3.4.11.Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

**3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой.**

3.1. Илрүүлэлт:

Санхүү албаны дарга нь төрийн сангийн мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн мэргэжилтний ажлын байранд ашиг сонирхлын зөрчилтэй албан тушаалтныг хавсран ажиллуулахгүй байх

3.2. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 157.4 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс 3.4 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2.6 сая төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, 13.8 сая төгрөгийн зөрчилд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлж, 137.5 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах АШ | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Хүний тоо | Тоо | Дүн |
| Ажил хавсран гүйцэтгэсэн | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| ХХС хугацаа хэтэрсэн зээл | 1 | 69.6 | | | | | 1 | 69.6 | | | | |
| Орлогыг нэр төрлөөр нь ханган биелүүлээгүй | 1 | 68.4 | | | | | 1 | 68.4 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн ирүүлээгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| | 4 | 138.0 | | | | | 4 | 138.0 | | | | |
| Харьяа байгууллагуудын зөрчил | | | | | | | | | | | | |
| ЗДТГ | 6 | 154.2 | 1 | 0.2 | 1 | 13.8 | 3 | 137.5 | 1 | **1** | | |
| ИТХ | 1 | 3.2 | 1 | 3.2 | | | | | | | | |
| Нийт дүн | **11** | **295.4** | 2 | 3.4 | 1 | 13.8 | **7** | **275.5** | 1 | **1** | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 3 | 1 | 2 | | 1 | | | |
| 2 | ЗГТС | 2 | | 2 | | | | | |
| 3 | ТТЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **6** | **2** | **4** | | **2** | | | |